



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

**Х.Ерхуланыг ажлаас чөлөөлөх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.4.1 дэх хэсэг, 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэг, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 5.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 178 дугаар тогтоолоор “Хангалтгүй” дүгнэгдсэн “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Х.Ерхуланыг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, түүнтэй байгуулсан 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 2024/09 тоот Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгосугай.

2.Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсонтой холбогдуулан Х.Ерхулантай ажилласан хугацааны цалин хөлс, ээлжийн амралтын тооцоо, эд хөрөнгийн тооцоог зохих журмын дагуу хийж дуусгахыг “Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын нягтлан бодогч Ж.Жавзандуламд даалгасугай.

3.“Монгол Кувейтын байгаль хамгаалах төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн дотор зохих журмын дагуу хүлээлцүүлэхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ